АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Эрдэнэбулган сумын Хүүхдийн Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/104-НА-СТА-ТШЗ

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2023 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Гэрээгээр аудит гүйцэтгэсэн: “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК<br>Захирал С.Оргил<br>Утас: 9919-7346<br>Цахим хаяг: shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 77

танай ____________-ны №____________-т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИРЭЭДҮЙ ЦОГЦОЛБОР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ С.ХОРЛООСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ирээдүй Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн Ирээдүй цогцолбор цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбулган сумын хүүхдийн Ирээдүй цогцолбор цэцэрлэг нь 150 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд 2023 онд 190 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулсан. Тайлант онд Боловсролын газраас 5,967.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 17.8 хувиар өссөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын үнэлгээний төвөөс багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 3 дүгээр түвшинд үнэлэгджээ.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 үндсэн зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 95 хувь гэж үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 93,924,695.56 | 73,488,263.34 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 61,854,235.56 | 40,082,696.61 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 61,854,235.56 | 40,082,696.61 |
| 3121 | Төгрөг | 61,854,235.56 | 40,082,696.61 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 61,854,235.56 | 40,082,696.61 |
| 33 | АВЛАГА | | 8,585.73 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 8,585.73 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 32,070,460.00 | 33,396,981.00 |
| 351 | Түүхий эд материал | 6,563,220.00 | 6,563,220.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 3,608,220.00 | 3,608,220.00 |
| 3513 | Эм боох материал | 2,955,000.00 | 2,955,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 25,507,240.00 | 26,833,761.00 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 1,069,460.00 | 942,560.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 20,615,850.00 | 23,727,151.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 540,000.00 | |
| 3545 | Барилгын засварын материал | 2,980,350.00 | 1,936,350.00 |
| 3546 | Хүнсний материал | 301,580.00 | 227,700.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 667,748,548.60 | 644,036,657.11 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 667,748,548.60 | 644,036,657.11 |
| 392 | Биет хөрөнгө | 667,748,548.60 | 644,036,657.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 664,000,000.00 | 664,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -26,066,666.58 | -37,133,333.22 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 31,507,684.74 | 23,689,667.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -19,638,151.43 | -10,782,127.13 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 61,876,001.50 | 26,395,017.65 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -44,768,769.63 | -22,971,017.43 |
| 39217 | Ном | 838,450.00 | 838,450.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 761,673,244.16 | 717,524,920.45 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 18,180,241.74 | 10,445,293.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 18,180,241.74 | 10,445,293.00 |
| 413 | Өглөг | 18,180,241.74 | 10,445,293.00 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 7,980,241.74 | |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 10,200,000.00 | 10,445,293.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 743,493,002.42 | 707,079,627.45 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 743,493,002.42 | 707,079,627.45 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 52,849,236.00 | 52,849,236.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 52,849,236.00 | 52,849,236.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 684,155,651.77 | 647,742,276.80 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 684,155,651.77 | 684,155,651.77 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -36,413,374.97 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 6,488,114.65 | 6,488,114.65 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 761,673,244.16 | 717,524,920.45 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,252,245,483.57 | 664,177,980.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 735,629,283.57 | 9,991,380.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 735,629,283.57 | 9,991,380.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 280,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 703,558,823.57 | 5,967,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 32,070,460.00 | 3,744,380.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 516,616,200.00 | 654,186,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 453,611,300.00 | 612,878,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 453,611,300.00 | 612,878,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 63,004,900.00 | 41,308,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,004,900.00 | 41,308,300.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 508,928,941.79 | 694,496,183.24 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 508,928,941.79 | 694,496,183.24 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 501,103,557.79 | 686,461,883.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 318,019,448.64 | 462,890,672.53 |
| 210101 | Үндсэн цалин | 235,685,193.94 | 311,413,442.30 |
| 210102 | Нэмэгдэл | 40,528,829.35 | 106,729,777.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,303,500.00 | 20,456,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,501,925.35 | 24,291,452.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,030,583.54 | 60,586,823.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,493,541.53 | 40,951,423.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,232,108.06 | 4,999,121.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,484,886.39 | 3,836,278.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 607,831.39 | 982,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,212,216.17 | 9,818,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 25,149,600.00 | 38,093,593.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,558,258.61 | 5,433,371.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,076,700.00 | 29,440,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,514,641.39 | 3,220,222.00 |
| 2105 | Нормативт зардал | 50,266,630.64 | 72,411,580.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,266,630.64 | 72,411,580.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,285,920.00 | 5,044,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,285,920.00 | 5,044,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 170,000.00 | 1,182,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 170,000.00 | 1,182,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,181,374.97 | 46,252,713.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,259,760.00 | 18,504,194.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,404,440.00 | 4,164,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,517,174.97 | 23,583,719.76 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,825,384.00 | 8,034,300.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,825,384.00 | 8,034,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,850.00 | 348,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,793,534.00 | 7,686,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 743,316,541.78 | -30,318,203.24 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 6,095,171.73 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 6,095,171.73 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -6,095,171.73 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 743,316,541.78 | -36,413,374.97 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 516,616,200.00 | 654,466,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 280,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 280,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 280,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 516,616,200.00 | 654,186,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 453,611,300.00 | 612,878,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 453,611,300.00 | 612,878,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 63,004,900.00 | 41,308,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,004,900.00 | 41,308,300.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 453,055,064.44 | 676,238,138.95 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 453,055,064.44 | 676,238,138.95 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 442,641,711.44 | 668,552,138.95 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 308,898,134.90 | 470,879,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 228,468,682.21 | 319,402,269.77 |
| 210102 | Нэмэгдэл | 39,083,035.35 | 106,729,777.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,272,681.00 | 20,456,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,073,736.34 | 24,291,452.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,551,836.54 | 60,586,823.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,161,384.21 | 40,951,423.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,195,460.64 | 4,908,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,455,568.86 | 3,926,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 600,501.50 | 982,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,138,921.33 | 9,818,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,339,900.00 | 37,308,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,558,258.61 | 5,433,371.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,267,000.00 | 28,654,707.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,514,641.39 | 3,220,222.00 |
| 2105 | Нормативт зардал | 49,010,210.00 | 72,678,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 49,010,210.00 | 72,678,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,679,870.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,679,870.00 | 4,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,258,000.00 | 1,182,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,258,000.00 | 1,182,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,903,760.00 | 21,916,315.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,533,760.00 | 18,368,915.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,370,000.00 | 3,547,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,413,353.00 | 7,686,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,793,534.00 | 7,686,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,793,534.00 | 7,686,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,619,819.00 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,619,819.00 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 63,561,135.56 | -21,771,538.95 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,706,900.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 1,706,900.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,706,900.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -1,706,900.00 | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 61,854,235.56 | -21,771,538.95 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 61,854,235.56 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 40,082,696.61 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | ЗГ-ын хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 52,849,236.00 | 6,488,114.65 | 684,155,651.77 | 743,493,002.42 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 52,849,236.00 | 6,488,114.65 | 684,155,651.77 | 743,493,002.42 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 52,849,236.00 | 6,488,114.65 | 684,155,651.77 | 743,493,002.42 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -36,413,374.97 | -36,413,374.97 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 52,849,236.00 | 6,488,114.65 | 647,742,276.80 | 707,079,627.45 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 716,320,800.00 | 676,238,138.95 | 40,082,661.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 716,320,800.00 | 676,238,138.95 | 40,082,661.05 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 708,634,800.00 | 668,552,138.95 | 25,379,761.05 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 490,879,500.00 | 470,879,500.00 | 20,000,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 328,731,700.00 | 319,402,269.77 | 9,329,430.23 |
| 210102 | Нэмэгдэл | 147,449,300.00 | 106,729,777.74 | 40,719,522.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 20,456,000.00 | -20,456,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,698,500.00 | 24,291,452.49 | -9,592,952.49 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 61,360,100.00 | 60,586,823.95 | 773,276.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,724,700.00 | 40,951,423.95 | 773,276.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,908,500.00 | 4,908,500.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,926,900.00 | 3,926,900.00 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 982,000.00 | 982,000.00 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,818,000.00 | 9,818,000.00 | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 37,308,300.00 | 37,308,300.00 | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,006,700.00 | 5,433,371.00 | 2,573,329.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22,450,000.00 | 28,654,707.00 | -6,204,707.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,851,600.00 | 3,220,222.00 | 3,631,378.00 |
| 2105 | Нормативт зардал | 77,285,100.00 | 72,678,700.00 | 4,606,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,285,100.00 | 72,678,700.00 | 4,606,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,182,500.00 | 1,182,500.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,182,500.00 | 1,182,500.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,916,400.00 | 21,916,315.00 | 85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,369,000.00 | 18,368,915.00 | 85 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,547,400.00 | 3,547,400.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,686,000.00 | 7,686,000.00 | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,686,000.00 | 7,686,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,686,000.00 | 7,686,000.00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 716,320,800.00 | 654,466,600.00 | 61,654,200.00 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 612,878,300.00 | 612,878,300.00 | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 612,878,300.00 | 612,878,300.00 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 41,308,300.00 | 41,308,300.00 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 41,308,300.00 | 41,308,300.00 | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 62,134,200.00 | 280,000.00 | 61,854,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 280,000.00 | 280,000.00 | 0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 61,854,200.00 | | 61,854,200.00 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 61,854,235.56 | -61,854,235.56 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 40,082,696.61 | -40,082,696.61 |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | |
| 5 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 25 | 25 | |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 11 | 11 | |
| 8 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 | |
| 9 | Гэрээт ажилтан | 2 | 2 | |
| 10 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 190 | 190 | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .

Аудитаар алдаа илрээгүй, 1 зөрчилтэй асуудал илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын дүн 5,014.2 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроосон | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |